



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/41

Өлгий

Г Эцэг, эхийн зөвлөл байгуулах тухай Г


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Хүүхдийн эрхийг хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйл, Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 5, 6, 7, 8, 9, 10 дугаар зүйл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны “Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого”, чиглэл батлах тухай 03 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын “Хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах” тухай 2018 оны 01 дүгээр албан даалгаврын 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хүүхдийн эрх, хамгааллын чиглэлээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллагын албан хаагчийн хүүхдийг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсролын ач холбогдлыг сурталчлан таниулах, сургалт зохион байгуулах, хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдийг аливаа эрсдэлд өртөх, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд ээлтэй байгууллага хамт олон болоход дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий байгууллагын эцэг, эхийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, “Эцэг, эхийн зөвлөлийн ажиллах журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. “Эцэг, эхийн зөвлөлийн ажиллах журам”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөлийн дарга (Т.Рахат)-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/41 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ *Анжелика* АНЖЕЛИКА



Эрүүл мэндийн газрын даргын
2026 оны 05 сарын 15 өдрийн
А/... тоот тушаалын 1 хавсралт



Зөвлөлийн дарга:

Т.Рахат –Хоол тэжээл, хүнсний аюулгүй байдлын асуудал хариуцсан ажилтан

Тэргүүлэгч:

Х.Атина - Уламжлалт анагаах ухаан, сэргээн засал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан ажилтан

Нарийн бичгийн дарга:

А.Динкелди- Сүрьеэ, БЗДХ өвчний асуудал хариуцсан ажилтан

Гишүүд:

М.Амангүл – Архив бичиг хэргийн ажилтан

Б.Айжибек – Дүн бүртгэлийн ажилтан

С.Бекет – Барилгын чанар, аюулгүй байдал, эмнэлгийн тоног, төхөөрөмж хариуцсан ажилтан